



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 5/120

Улаанбаатар хот

Гадаад улсад албан томилолтоор  
ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Эрүүгийн цагдаагийн албаны Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хошууч Сангарагчаагийн Ариунболор, мөн хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Төмөртоогогийн Очирболд, Захиргааны удирдлагын хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Мөнх-Очирын Бат-Эрдэнэ, Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч Энхтөрийн Цэнгүүн нарыг “Электрон хэрэгсэл, олон нийтийн сүлжээ, даркнет, кибер гэмт хэргийг мөрдөн шалгахад ашиглах гүйцэтгэх ажлын техник технологи” сэдэвт олон улсын хуралд оролцуулах зорилгоор 2019 оны 03 дугаар сарын 09-15-ны өдрүүдэд Арабын Нэгдсэн Эмират Улсад албан томилолтоор ажиллуулсугай.

2. Албан томилолтоор ажиллах алба хаагчдад шаардагдах зардлыг батлагдсан төсвийн дагуу тооцож олгохыг Санхүү, аж ахуйн албаны дарга /цагдаагийн хурандаа Ж.Эрдэнэболд/-д зөвшөөрсүгэй.

3. Дүнг ирснээс хойш ажлын 3 хоногт багтаан илтгэх хуудсаар танилцуулахыг цагдаагийн хошууч С.Ариунболорт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газар /цагдаагийн хурандаа Б.Бат-Өлзий/-т даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА



С.БААТАРЖАВ

0900837